



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 02 өдөр

Дугаар АН07

Мандалговь

Сургалт нөлөөллийн үйл ажиллагааг  
төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалт, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2018-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.55 дахь заалт, Дундговь аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны үндсэн чиглэлийн 2.3.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн шууд захирагчаас Төрийн жинхэнэ албан хаагчтай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрэгтэйчүүд, ялангуяа 18-35 насныханд зориулсан жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, үндэсний уламжлалт, дэвшилтэд зан үйл, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор "Хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай" сургалт нөлөөллийн үйл ажиллагааг "Гэрэлтдэг ертөнц" төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсүгэй.

2. "Хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай" сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөг 1 дүгээр, шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 620,400 (Зургаан зуун хорин мянга дөрвөн зуу) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бүжинлхам)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бүжинлхам), гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

482201013

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 02 дүгээр сарын 02-ны өдрийн 1027 тоот тушаалын 01 дүгээр хавсралт



**“ХУЧИРХИЙЛЭЛ ХҮН БҮХЭНД ХАМААТАЙ” СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Сургалтын цаг	Төсөв	Хүрэх үр дүн
1	Сургалтын агуулга төлөвлөгөө гаргах	2021.12.09	-	-	
2	Харилцааны хэв шинжээ тодорхойлох ➤ Судалгаа авах Харилцааны хэв шинжүүдийн мэдээлэл өгөх	2021.12.10	3 цаг	155,100	...
3	“Жеңдэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл” сэдэвт сургалт	2021.12.12	3 цаг	155,100	Сургалт нөлөөллийн үйл ажиллагааг нийт 124 эрэгтэйчүүдэд зохион байгуулж, харилцааны хэв шинжийг тодорхойлж, өөрт байгаа муу зуршлаасаа татгалзаж эерэг зуршлуудыг өөртөө бий болгох, аргад суралцана.
4	“Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалт	2021.12.14	3 цаг	155,100	
3	1.Бид хэн бэ? Бид хаана байна вэ?Бид хаа хүрэх вэ? Сэдэвт сургалт	2022.01.28	3 цаг	155,100	
<b>Нийт:</b>				<b>620,400</b>	

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2022 оны 02 дүгээр сарын 01-ны өдрийн  
№09 тоот тушаалын 02 дүгээр хавсралт

**"ХҮЧИРХИЙЛЭЛ ХҮН БҮХЭНД ХАМААТАЙ" СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО**

№	Зардлын ангилал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Сургагч багшийн хөлс	цаг	51,700	12	620,400
<b>Нийт</b>					<b>620,400</b>